



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/123

Цагаан-Уул сум

**Малын бруцеллёз өвчнөөс урьдчилан
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын “Бруцеллёзын дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/276 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг сумын хэмжээнд бүх эм тугал, хурга, ишгийг хамруулан 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Бруцеллёзын дархлаажуулалтад хамрагдах малын тоо, шаардагдах вакцины хуваарийг нэгдүгээр хавсралтаар, дээрх үйл ажиллагааг сумын хэмжээнд баг тус бүрээр зохион байгуулах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дархлаажуулалтад шаардагдах вакциныг хуваарилан олгож, мэргэжил арга зүй, заавар зөвлөмжөөр хангаж, гүйцэтгэлийн болон технологийн явцад хяналт тавьж, тайлан мэдээг холбогдох газарт хүргүүлэн ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга, хяналтын улсын байцаагч (Т.Чандмаа) мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч малын эмч (М.Дуламжав) нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (У.Аварзэд)-д даалгасугай.

ДАРГА  С.ГОНЧИГНЯМ

